



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/05



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 05 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны 05 сард 582 эх амаржиж, 585 хүүхэд шинээр мэндэлж, 137 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 62(11.9%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 63(12.1%)-аар тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 30(18.0%)-аар буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 448 болж 2019 оны мөн үеийнхээс 93(26.2%)-аар өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 8.3, нас баралт 1.9 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.7 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 05 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өсчээ.



1.2 Эрүүл мэнд


2020 оны 05 сарын байдлаар 171.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурч, 7.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар, 5.1 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 110.9 хувиар тус тус өсчээ.

2020 оны 05 сард 773 эх жирэмсний хяналтанд орсны 91.3 хувь буюу 706 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 8.8 мянган удаа гарсны 1.6 мянга буюу 18.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар өсч, нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 1183 хүн бэртэж, 21 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 18(1.5%)-аар өсч, нас барсан хүний тоо 12(36.4%)-оор буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 05 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 27.7 хувь, бусад төрлийн өвчин 23.4 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 22.6 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 15.3 хувь, хоол шингээх эрхтний өвчин 10.9 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 322 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 85-аар буюу 20.9 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад тэмбүү 32.3 хувиар, трихоминиаз 41.2 хувиар, цусан суулга 7.7 хувиар, бусад төрлийн өвчин 33.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 05 сарын эцэст 468 болсны 426(91.0%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 42 (9.0%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 417(52.9%) хүнээр буурч, өмнөх сараас 32(6.8%) хүнээр өсчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 224(47.9%) нь бүрэн дунд, 105(22.4%) нь дээд, 53(11.3%) нь тусгай дунд, 44(9.4%) нь бүрэн бус дунд, 29(6.2%) нь техник мэргэжлийн, 9(1.9%) боловсролгүй, 3(0.6%) бага боловсролтой, 1(0.2%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 05 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 5 сарын байдлаар 88 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 161 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 118 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 05 сарын байдлаар 16838.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 246.8 (1.4%) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 05 сард өмнөх оны мөн үеэс 246.8 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн даатгал 197.5 (1.8%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 21.0 (1.7%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгал 17.7 (1.0%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 13.3 (0.5%), сая төгрөгөөр буурсан байна.




төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 888(4.3%)-аар буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 7.3(0.2%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 05 сард 1312 хүн хамрагдсан нь өмнөх оноос 124(8.6%)-өөр буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 243.2(23.3%) сая төгрөгөөр өсчээ.


Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1069 иргэнд 446.1 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 892 иргэнд 304.3 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 5396 иргэнийг хамруулж, 347.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11055 иргэн хамрагдаж, 1080.8 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 05 дугаар сарын байдлаар 176 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 46 хүн гэмтэж, 4 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 66 (27.3%)-аар, гэмтсэн хүний тоо 46 (50.0%) -аар, нас барсан хүний тоо 10 (71.4%)-аар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 11(12.8%)-ээр, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(33.3%)-ээр тус тус өсч, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 7(70.0%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 46 (59.7%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8 (57.1%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7(43.8%)-оор, олон нийтийн аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3(25.0%)-аар, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(50.0%)-ээр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 1(7.7 %) -ээр тус тус буурч, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 55.1 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 17.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 6.8 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 5.1 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 5.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3.4 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 6.9 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 30 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27(47.4%)-оор буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Сайхандулаан, Хөвсгөл сумдад нэмэгдэж, Даланжаргалан суманд өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 550.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1873.7 (72.2%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 329.7 (59.9%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 49(27.8%) нь гэр орон сууцандаа, 30(17.0%) нь согтуугаар, 21(11.9%) нь гудамж олон нийтийн газарт, 19(10.8%) бүлэглэн, 15(8.5%) хувийг эмэгтэй хүн оролцон, 60(34.1%) нь өдрийн цагаар /14-19 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 470 хүн саатуулагдаж, 89 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 05 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 35.2 мянга болж өмнөх оноос 1.2(3.5%) мянган хүнээр өсч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 70.2 мянга болж өмнөх оны мөн үеээс 1.5 хувиар буурсан байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019- 2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 133.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1908.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1924.8 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.2(31.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 10.0 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.5(6.0%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 5.3(2.0²) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн


өрийн үлдэгдлийн 3.8 хувийг эзэлж, өмнөх сартай адил, өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 10.8 тэр бум төгрөг болж өмнөх сараас 4007.7(58.7%)сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4047.1(59.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.7пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.05 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.5 сард



2.2 Төсөв, санхүү

2020 оны 05 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 14478.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 68.4 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 50.0 хувиар буурсан байна / 2020 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлогын дүн тусгагдаагүй/. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 74.9 хувийг татварын, 25.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 05 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 4423.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 6.2 хувь буюу 256.3 сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 7.0 хувь буюу 290.3 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 05 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.1 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.1 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 0.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 8.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 2.1 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 7.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 3.7 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 4.6 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 0.1 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур

байрны үйлчилгээний бүлэг 7.9 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 1.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 05 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 05 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1010.6 мянган хээлтэгч малын 679.1 мянга (67.2%) нь 2020 оны эхний 05 сард төллөсөн байна. Эм хонины 76.6 хувь, эм ямааны 65.2 хувь, ингэний 40.0 хувь, үнээний 41.1 хувь, гүүний 28.8 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.9 хувь буюу 682.6 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 38.0 (5.9%) мянгаар бага байна. Дэлгэрэх суманд 71.4 мянга, Айраг суманд 66.5 мянга, Даланжаргалан суманд 64.9 мянга, Иххэт суманд 59.9 мянга, Хатанбулаг суманд 57.6 мянга, Алтанширээ суманд 55.6 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 55.1 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны 05 сард аймгийн хэмжээнд 729 болж, өмнөх оны мөн үеэс 3129(81.1%) толгойгоор буурсан байна. Нийт хорогдсон малын 57.2 хувийг ямаа, 31.1 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 05 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах суманд хамгийн их буюу 1400.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Сайхандулаан, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1100.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Хөвсгөл суманд хамгийн бага буюу 850.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Хөвсгөл суманд хамгийн бага буюу 130.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Эрдэнэ суманд хамгийн их буюу 170.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.

3.2 Аж үйлдвэр



Оны эхний 05 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 52316.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 94343.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 27.3 хувиар, борлуулалт 25.6 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 05 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 27.3 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 15221.1 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 4867.7 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 8.5 хувийг төрийн, 91.5 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 8.5 хувь, компани 90.8 хувь, өрхийн аж ахуй 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 19.6 мян.ккалаар, талх 67.4 тонноор, бялуу 0.1 тонноор, хэрчсэн гурил 18.6 мян.тн-оор, гутал 8 ширхгээр, шохой 700 тонноор, вакуум цонх 114.7 м²-аар, цаасан уут 5.0 мян.ширхгээр, модон эдлэл 5184.7 мян.төгрөгөөр, хайрга 4.3 мян.м³-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: Сарын дундаж агаарын температур Мандах, Дэлгэрэх, Эрдэнэ сумдад 14.2...14.8 градус, бусад сумдын нутгаар 15.3...18.3 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдад 31...34 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Сайншнад, Мандах, Хөвсгөл сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдад ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө Мандах, Алтанширээ, Эрдэнэ, Өргөн сумдад 2...4 градус хүйтэн, бусад сумдад 0...2 градус дулаан, өдөртөө нийт сумдад 51...60 градус дулаан байв.

Хур тунадас: 5 дугаар сард Иххэт суманд 39.1 мм, Дэлгэрэх суманд 28.8 мм, Айраг суманд 14.2 мм, Өргөн суманд 12.9 мм, бусад сумдын нутгаар 2.2...8.6 мм тунадас орсон. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Дэлгэрэх, Иххэт, Айраг, Өргөн сумдад ОЖД-аас ахиу, Хөвсгөл, Алтанширээ, Сайхандулаан сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас бага тунадас орсон байна.



Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Улаанбадрахаас бусад сумдын нутгаар секундэд 16...24 метр хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. 10м/с-ээс дээш салхитай 10...28 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 5 дугаар сарын 25-ны байлаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр 2-7 см, бэлчээрийн ургамлын ургалтын байдал сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр Замын-Үүд сум, Эрдэнэ сумын баруун болон өмнө, Өргөн сумын зүүн, Дэлгэрэх, Хатанбулаг сумдын зүүн болон хойд, Даланжаргалан, Иххэт сумдын хойд, Хөвсгөл сумын хойноос бусад хэсгээр сайн, Сайхандулаан сумын өмнө, Мандах сумын нутгаар маш муу буюу цухуйлтгүй, Сайншанд сум, Сайхандулаан сумын өмнөөс бусад, Дэлгэрэх, Иххэт сумдын баруун болон өмнө, Алтанширээ сумын хойд болон өмнө хэсгээр муу, бусад нутгаар дунд зэрэг байна.

МАН-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Сумдын нутгаар бод мал төллүүлэх, мал оторлох ажил явагдаж байна. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.

_____ о О о _____



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2020 ОНЫ 05 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган	68.2	69.6	69.9	70.6	101.0
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	523	565	522	585	112.1
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	147	160	167	137	82.0
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	376	405	355	448	126.2
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	3	1	3	8	2.7 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	5.7	1.8	5.7	13.7	2.4 ²
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 650	860	885	468	52.9
- Үүнээс эмэгтэй	тоо	704	408	443	224	50.6
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	38	20	204	109	53.4
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	121	92	3	88	29.3 ²
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	121	65	2	85	42.5 ²
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	27	1	3	3 ²
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	447	306	407	322	79.1
- 10000 хүнд ногдох	тоо	66	44	58	45	77.7
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	276	251	242	176	72.7
- 10000 хүнд ногдох ***	тоо	64	58	54	40	72.7
6.Бойжиж буй төл	толгой	518330	540011	644608	682569	105.9
- Унага	толгой	11900	12312	11046	14351	129.9
- Тугал	толгой	9640	11291	9182	15058	164.0
- Ботго	толгой	5714	5834	6272	6854	109.3
- Хурга	толгой	264407	274539	331397	347467	104.8
- Ишиг	толгой	226669	236035	286711	298839	104.2
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	35308.0	79542.4	71966.6	52316.8	72.7
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	69985.6	112477.0	126852.3	94313.2	74.3

* - 2017,2018,2019 оны жилийн эцэст

** -Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 I-V	2020 I-V	Өсөлт	
		тоо			хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	171.5	171.0	-0.5	99.7
2. Ор хоног	мян.хүн	53.0	54.4	1.4	102.6
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	4.6	5.1	0.5	110.9
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	7.4	7.8	0.4	105.4
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	8.8	8.8	0	100.0
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.3	1.6	0.3	123.1
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1165	1183	18	101.5
Үүнээс: нас баралт	хүн	33	21	-12	63.6
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	775	773	-2	99.7
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	690	706	16	102.3
8. Амаржсан эх	хүн	520	582	62	111.9
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	2	0	-2	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	3	8	5	3.5 ²

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 05 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	
	тоо				
Дүн	582	0	585	8	0
Айраг					
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах	1		1		
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл					
Эрдэнэ	1		1	1	
Сайншанд	451		454	6	
Замын - Үүд	126		126	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	407	322	-85	79.1
Вируст гепатит	3	3	0	0.0
Сүрьеэ	35	33	-2	94.3
Тэмбүү	65	44	-21	67.7
Заг хүйтэн	96	93	-3	96.9
Трихоминиаз	68	40	-28	58.8
Цусан суулга	17	27	10	158.8
Бусад	123	82	-41	66.7

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 05 сард

Боловсролын түвшингээр	2017 V	2018 V	2019 V	2020 V	2020 V 2017 V	2020 V 2019 V
	хүний тоо				хувь	
ДҮН	1 650	860	885	468	28.4	52.9
Үүнээс: Эмэгтэй	804	408	443	224	27.9	50.6
Магистр, доктор	7	1	2	1	14.3	0.0
Дээд боловсролтой	385	168	114	105	27.3	92.1
Тусгай дунд	148	43	36	53	35.8	147.2
Техник мэргэжлийн	138	55	37	29	21.0	78.4
Бүрэн дунд	763	515	596	224	29.4	37.6
Бүрэн бус дунд	157	52	67	44	28.0	65.7
Бага	29	6	13	3	10.3	23.1
Боловсролгүй	23	20	20	9	39.1	45.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 05 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2019 V	2020 V	2019 V	2020 V	2019 I-V	2020 I-V
ДҮН	885	468	220	161	3	756
Айраг	42	21	2	1	1	29
Алтанширээ	25	7	17	3	0	13
Даланжаргалан	40	4	20	0	0	6
Дэлгэрэх	12	2	5	0	0	8
Иххэт	16	6	1	0	0	10
Мандах	9	3	0	0	0	6
Өргөн	12	3	68	1	2	16
Сайхандулаан	15	10	2	2	0	6
Улаанбадрах	10	5	11	1	0	17
Хатанбулаг	12	13	7	29	0	41
Хөвсгөл	9	4	5	0	0	6
Эрдэнэ	44	24	8	5	0	44
Сайншанд	460	237	34	106	0	410
Замын - Үүд	179	129	40	13	0	144

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2020 оны 05 сарын эцэст

Салбарын ангилал	2019 I-V	2020 I-V
	Тоо	
Бүгд	231	383
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	19	7
Уул уурхай олборлох аж үйлдвэр	99	4
Боловсруулах үйлдвэрлэл		1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	17
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын Барилга	6	1
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн Тээвэр агуулахын үйл ажиллагаа		119
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	24
Мэдээлэл, холбоо	2	7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	4	0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл		1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		22
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа,	21	45
Боловсрол	13	23
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	4	26
Урлаг, үзвэр,тоглоом наадам		15
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	60	61
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн		0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл		0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2020 оны 05 сарын эцэст

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V
	Тоо	
Бүгд	231	383
Менежер	5	5
Мэргэжилтэн	32	101
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	37	29
Контор, үйлчилгээний ажилтан	9	15
Худалдаа, үйлчилгээний ажилтан	11	56
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	10	34
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	18	31
Энгийн ажил мэргэжил	93	65
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	47

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2019 I-V		2020 I-V	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	220	92	161	64
Менежер	3	3	1	1
Мэргэжилтэн	31	24	31	19
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	36	13	12	8
Контор, үйлчилгээний ажилтан	9	9	9	6
Худалдаа, үйлчилгээний ажилтан	9	7	32	18
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	5	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	10	3	19	7
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	17	1	19	0
Энгийн ажил мэргэжил	89	26	36	5
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	1	2	0

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2020 оны 05 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	88	41	85	3
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур				
Уул уурхай олборлолт	1	1		1
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	8	3	8	
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	30	2	30	
Барилга				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	7	5	7	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	2	2		2
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	7	4	7	
Мэдээлэл холбоо	2	1	2	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2		2	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал				
Боловсрол	21	15	21	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам	5	5	5	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3	3	3	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V	2020 I-V 2019 I-V
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	17 085.7	16 838.9	98.6
Тэтгэврийн даатгалын сан	10783.2	10 585.7	98.2
Тэтгэмжийн даатгалын сан	1222.0	1 201.0	98.3
Эрүүл мэндийн даатгалын сан	2809.5	2 796.2	99.5
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1780.7	1 763.0	99.0
Ажилгүйдлийн даатгалын сан	490.3	493.0	100.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага	20 999.2	24 368.3	116.0
Тэтгэврийн даатгалын сан	15246.5	18 005.4	118.1
Тэтгэмжийн даатгалын сан	1210.8	1 539.7	127.2
Эрүүл мэндийн даатгалын сан	2879.5	2 973.6	103.3
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1248.1	1 194.4	95.7
Ажилгүйдлийн даатгалын сан	414.3	655.2	158.1

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сард

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V	2020 I-V 2019 I-V
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	19719	19809	100.5
Албан журмаар даатгуулагчид	16370	16546	101.1
Аж ахуй нэгж, байгууллага	8646	8650	100.0
Төсөвт байгууллага	7724	7896	102.2
Сайн дураар даатгуулагчид	3349	3263	97.4
2. Тэтгэвэр авагчдын тоо	8537	9055	106.1
Өндөр насны тэтгэвэр	6136	6593	107.4
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1281	1326	103.5
Тэжээгчээ алдсаны	504	491	97.4
Цэргийн тэтгэвэр	438	475	108.4
ҮОМШӨ*-ний	178	170	95.5
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	16 489.4	18 998.7	115.2
Өндөр насны тэтгэвэр	11 341.3	13 270.3	117.0
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1 784.8	2 106.1	118.0
Тэжээгчээ алдсаны	740.9	831.3	112.2
Цэргийн тэтгэвэр	1 374.3	1 596.6	116.2
ҮОМШӨ*-ний	1 248.1	1 194.4	95.7

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I-V	2020 I-V	2020 I-V 2019 I-V
	сая төгрөг		хувь
ДҮН	17085.7	16838.9	98.6
Айраг	312.9	263.3	84.1
Алтанширээ	99.2	117.2	118.1
Даланжаргалан	791.4	741.0	93.6
Дэлгэрэх	133.3	132.7	99.5
Иххэт	211.5	225.7	106.7
Мандах	132.2	125.8	95.2
Өргөн	595.6	328.4	55.1
Сайхандулаан	155.2	135.0	87.0
Улаанбадрах	134.9	141.7	105.0
Хатанбулаг	312.6	313.5	100.3
Хөвсгөл	130.6	136	104.1
Эрдэнэ	242.1	271.7	112.2
Сайншанд	9661.9	9463.6	97.9
Зүүнбаян баг	488.1	501.3	102.7
Замын-Үүд	3684.2	3942	107.0

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I-V	2020 I-V	2020 I-V 2019 I-V
	сая төгрөг		хувь
ДҮН	20999.2	24368.3	116.0
Айраг	1032.1	1150.4	111.5
Алтанширээ	385.1	447.3	116.2
Даланжаргалан	938.4	1042.6	111.1
Дэлгэрэх	426.0	524.5	123.1
Иххэт	752.3	824.5	109.6
Мандах	428.3	520.9	121.6
Өргөн	870.3	750.1	86.2
Сайхандулаан	302.4	370.4	122.5
Улаанбадрах	455.5	515.8	113.2
Хатанбулаг	827.2	902.0	109.0
Хөвсгөл	372.0	450.5	121.1
Эрдэнэ	693.6	820.7	118.3
Сайншанд	8928.6	10672.4	119.5
Зүүнбаян баг	758.4	876.2	115.5
Замын-Үүд	3829.0	4500.0	117.5



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-V
	2019 I-V	2020 I-V	2019 I-V	2019 I-V	2020 I-V	2019 I-V
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	20612	19724	95.7	3459.1	3466.4	100.2
1. Халамжийн тэтгэвэр	1436	1312	91.4	1045.0	1288.2	123.3
Ахмад настны тэтгэвэр	81	93	114.8	56.1	89.4	159.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1355	1219	90.0	988.9	1198.7	121.2
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1035	1069	103.3	322.6	446.1	138.3
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	982	1014	103.3	302.5	422.77	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	45	50	111.1	16.9	21.3	126.3
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	5	83.3	2.5	2.0	79.1
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2	0	0.0	0.7	0.0	0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн		0			0.0	
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	825	892	108.1	264.4	304.3	115.1
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	315	232	73.7	172.1	225.9	131.3
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	371	631	0.0	35.9	38.8	0.0
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	130		0.0	40.8	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	6	6	0.0	12.0	12.0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-V 2019 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-V 2019 I-V
	2019 I-V	2020 I-V		2019 I-V	2020 I-V	
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	3	0.0	1.2	3.6	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	19	0.0	1.2	22.8	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	0	0.0	1.2	0.0	0.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	0	1	0.0	0.0	1.2	0.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	6873	5396	78.5	262.9	347.1	132.0
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3434	1866	54.3	83.1	71.2	85.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	341	155	45.5	30.6	28.0	91.6
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0	84	0.0	0.0	2.2	0.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	2470	2269	91.9	58.4	220.6	377.7
Банкны шимтгэл				1.1	1.6	0.0
